



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/32

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.3.10, Аймгийн үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний уламжлалт сар шинийн баярыг угтаж үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг орон даяар сурталчлан таниулж, орон нутаг болон нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, кластер хөгжлийг дэмжих зорилгоор Улаанбаатар хотод зохион байгуулагдах "SME 1000+EXPO" арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

М.Анхбаяр - (Засаг даргын орлогч)

Гишүүд:

Н.Эрдэнэ-Очир - (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Мөнхжаргал - (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Цэрэнханд - (Хүнс хөдөө аж ахуйн газрын үйлдвэр, худалдаа үйлчилгээний албаны дарга)

Ж.Мөнхбаяр - (Хүнс хөдөө аж ахуйн газрын жижиг дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн)

Н.Батбаяр - (Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Дундговь салбарын дарга)

Нарийн бичгийн дарга:

Э.Мөнхзул (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. "SME 1000+EXPO" үзэсгэлэн худалдаанд оролцох ажлын хэсгийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. "SME 1000+EXPO" үзэсгэлэн худалдаанд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111769

Аймгийн засаг даргын 2023 оны...<sup>01</sup> дүгээр сарын...<sup>20</sup>  
өдрийн <sup>11/32</sup> дугаар захирамжийн хавсралт

“event week I” арга хэмжээг хариуцах хуваарь

№	Арга хэмжээний нэр	Хугацаа	Хариуцах эзэн
1	“EVENT WEEK I” хувцас хэрэглэл	2023.01.23 2023.01.29	Хүнс хөдөө аж ахуйн газар
2	“EVENT WEEK II” Бэлэг дурсгал	2023.01.30 2023.02.05	Хүнс хөдөө аж ахуйн газар
3	“EVENT WEEK III” Хүнс худалдаа	2023.02.06 2023.02.12	Хүнс хөдөө аж ахуйн газар